

## НҮҮРСНЭЭС БАЙГАЛИЙН ХИЙ ҮЙЛДВЭРЛЭХ ҮЙЛДВЭРИЙН ТӨСӨЛ

ТӨСЛИЙН ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ	
1. Төслийн нэр, хүчин чадал:	“Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр” төсөл, Хүчин чадал: Жилд 725 сая Нм <sup>3</sup> /жил нийлэг байгалийн хий болон 300 мян.тн өндөр чанарын бензин.
2. Төсөл хэрэгжих салбар, дэд салбар:	Хүнд үйлдвэр, нүүрс-химийн үйлдвэрлэлийн салбар
3. Төслийн хэрэгжих хугацаа:	Төслийн хэрэгжилтэд шаардагдах, урьдчилан таамаглаж буй нийт хугацаа 48-60 сар
4. Төслийн төсөвт өртөг/тэрбум ам.доллар /:	2.1
5. Хэрэгжүүлэгч яам, байгууллага:	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
ТӨСЛИЙН ТАЛААРХ НАРИЙВЧИЛСАН МЭДЭЭЛЭЛ	
6. Байршил	<u>Байршил:</u> Төслийн талбай Төв аймгийн Баяндэлгэр сумын Нүүргэлтийн хөндийд оршино, Хэрлэн голоос баруун зүг 11.5км зайд, Баяндэлгэр сумын төвөөс зүүн тийш 12км зайд, Багануур хотоос баруун өмнө зүгт 15км зайтай, засмал замаас 2.5км, төмөр замаас 2км, Багануур уурхайн төмөр замын ачих цэгээс 13км зайтай байрлана.
7. Бүтээгдэхүүн	- Нийлэг байгалийн хий, өндөр чанарын автобензин
8. Төслийн үндэслэл:	<ul style="list-style-type: none"> <li>- Улаанбаатар хот нь дэлхийн хамгийн их агаарын бохирдолтой хотуудын нэг бөгөөд агаарын бохирдлын үндсэн эх үүсвэр нь нүүрс гэх мэт хатуу түлш, автомашины утаа болохыг олон тооны судалгааны дүнгээр тодорхойлоод байна. Улаанбаатар хотын агаарын бохирдол жилээс жилд нэмэгдэж гамшгийн хэмжээнд хүрээд байгаа бөгөөд өвлийн улиралд агаарын бохирдол Монгол Улсын болон олон улсын агаарын чанарын стандартаас 4-24 дахин нэмэгдэж агаарын бохирдлоос үүдэлтэй амьсгалын замын өвчлөлийн эмчилгээнд жил бүр олон тэрбум төгрөг зарцуулж байна. УБ хотын агаарын бохирдлыг Монгол Улсын агаарын чанарын стандартын зөвшөөрөгдөх хэм хэмжээнд хүрэхийн тулд 80% хүртэл бууруулах шаардлагатай.</li> <li>- Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого”-ын 5.2.1.1 дэх хэсэгт “...нүүрснээс түлш, шатахуун гаргах технологийг эзэмших...” гэж, 5.3.3 дэх хэсэгт “Нүүрс хийжүүлж, бага оврын цахилгаан станцуудыг түлшээр хангана” гэж,</li> <li>- Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Нүүрсний нийлэг хийн үйлдвэр байгуулахыг бодлогоор дэмжинэ” гэж тус тус тусгагдсан.</li> </ul>
9. Төслийн зорилго:	Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах зорилгоор түүхий нүүрсний хэрэглээг нийлэг байгалийн хийгээр орлуулах, газрын тосны бүтээгдэхүүн болон бордоо зэрэг импортыг орлох бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлийг хөгжүүлэх юм.
10. Төслийн бэлтгэл:	- Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах төслийн хүрээнд Дэлхийн банкны санхүүжилтээр “Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр”-

	ийн Техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах болон Байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээг гүйцэтгэх төсөл хэрэгжиж байна.
11. Хүрэх үр дүн:	<ul style="list-style-type: none"> <li>- Төслийг хэрэгжүүлснээр тархалт элбэг, нөөц ихтэй хямд үнэтэй хүрэн нүүрсний үнэ цэнийг нэмэгдүүлж, нэмүү өртөг шингэсэн импортыг орлох эцсийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.</li> <li>- Нийлэг байгалийн хийг Улаанбаатар хот болон хий дамжуулах шугам хоолойн дагуу орших төвлөрсөн хот суурин газрын гэр хороолол, нам даралтын зуух, орон сууцны оршин суугчдын ахуйн хэрэглээ, тээврийн хэрэгслийн шатахууны зориулалтаар ашигласнаар Улаанбаатар хотын агаарын бохирдол эрчимтэй буурахын зэрэгцээ хотын захын хорооллын оршин суугчдын хөдөлмөрийг хөнгөвчилж амьдралын чанар дээшилнэ.</li> <li>- 1000 хүртэл ажлын байрыг шинээр бий болгоно.</li> </ul>
12. Нийгэм болон хүрээлэн байгаа орчны нөлөөлөл:	<ul style="list-style-type: none"> <li>- Жилд 4-5 сая.тн эрчим хүчний нүүрс боловсруулах хүчин чадалтай тус үйлдвэр ашиглалтад орсноор дотоодын нүүрс олборлогч аж ахуйн нэгжүүдийн олборлолт нэмэгдэж тогтвортой үйл ажиллагаагаар хангагдана.</li> <li>- Нүүрсний шууд шаталтаас үүсэх агаарын бохирдлыг дорвитой бууруулснаар агаарын бохирдлоос үүдэлтэй амьсгалын замын болон бусад өвчлөлийн хэмжээ эрс буурна</li> <li>- Нүүрсний нийлэг байгалийн хийг үйлдвэрлэх, дамжуулах, түгээхтэй холбоотой аж үйлдвэрийн шинэ салбар үүсэж, шууд болон шууд бус ажлын байрыг олноор бий болгож, орон нутгийн ажилгүйдлийн түвшин буурна.</li> </ul>